



“Энэхүү бүтээлийг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Азийн сангийн хамтран хэрэгжүүлж буй “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд МУИС-ийн Хууль зүйн сургууль болон Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн багш, судлаач оюутнуудын баг хийж гүйцэтгэв. Бүтээлд илэрхийлэгдсэн агуулга, дүгнэлт, санал нь судлаачдын үзэл санаа бөгөөд АНУ-ын засгийн газар эсхүл дээрх агентлаг, хүрээлэн, сангийн албан ёсны байр суурь биш болно.”

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД 2000 ОНД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

Монгол Улс түүхэндээ анхны Үндсэн хуулиа 1924 онд баталж улмаар 1940, 1960, 1992 онуудад шинэчлэн баталсан. 1992 оны Монгол Улсын дөрөв дэх Үндсэн хууль нь ардчилсан, шинэ Үндсэн хууль гэдгээрээ өмнөх хуулиудаас ялгаатай. Энэхүү Үндсэн хуулийг боловсруулах үйл явц 1989 оны 12 сард эхэлж, Үндсэн хуулийг боловсруулах ажлын хэсгийг анхны Ерөнхийлөгч П.Очирбат тэргүүлж, нэрт хуульч Б.Чимид нарийн бичгийн даргаар нь ажиллаж, олон намын төлөөллөөс бүрдсэн 20 гишүүнтэй комисс 1990-1992 онд судалгаа хийж, төслийг Улсын Бага Хурлаар 4 удаа, ард нийтээр 3 сар орчим хэлэлцүүлж, Ардын Их Хурлаар 70 гаруй хоног хэлэлцэн, шинэ Үндсэн хуулийг 1992 оны 1 дүгээр сарын 13 -ний өдөр батлан тунхагласан.

1992 оны Үндсэн хуулийн хүрээнд Монгол Улсад ардчиллыг тогтоох үйл явц өрнөж, парламентын тогтолцоог сонгож, төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн гурван салаа мөчирт хуваарилж, тэдгээрийн харилцан хяналт-тэнцлийг хангахын сацуу хүний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрч, баталгаажуулах үндэс суурийг тавьсан. Үндсэн хууль 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс дагаж мөрдөгдөж эхэлснээс хойш Монголын хууль, эрх зүйн орчин, улс төрийн тогтолцоо бүхэлдээ өөрчлөгдөж шинэ тутам сорилттой тулгарч байв. Тухайлбал, Ерөнхий сайдыг томилох, танхимыг бүрдүүлэх процессын талаар Ерөнхийлөгч, парламент чухам ямар бүрэн эрхтэй байхыг 1992 оны Үндсэн хуульд нарийвчлан тусгаагүй байсан. Өөрөөр хэлбэл Засгийн газарт хэн орж ажиллах, ийнхүү ажиллахын тулд парламентын гишүүнээс чөлөөлөгдөх шаардлагатай эсэх нь маргаантай зэрэг асуудал” байсан. Энэ мэтчилэн Үндсэн хуулийг хэрэгжүүлэх үйл явцтай холбогдуулан эрх мэдэл хоорондын уялдаа холбоо, харилцан тэнцлийг хангах, салбар салбарт тулгарч буй бэрхшээл, сорилт зэргийг үндэслэн хууль тогтоогчид Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзсэн учир 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Үндсэн хуулийн “22.2, 39.2, 24.1, 27.2, 27.6, 29.1, 33.1.2” зэрэг долоон зүйлд нэмэлт, өөрчлөлтийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан. Харин уг нэмэлт өөрчлөлтийг Үндсэн хуульд оруулахдаа Үндсэн хуулийг зөрчсөн хэмээн С.Нарангэрэл нарын иргэд 1999 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргажээ.

Ийнхүү Үндсэн Хуулийн Цэц өргөдлийг хүлээн авч 2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Их суудлын хуралдаанаараа уг асуудлыг хэлэлцэж “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт” нь Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2-т заасан “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, жаран наймдугаар зүйлийн 1-д заасан “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн Цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно”, далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн гэж үзэж уг нэмэлт, өөрчлөлтийг бүхэлд нь хүчингүй” болсон байдаг.

Харин 2000 оны Улсын Их Хурлын сонгуулиар шинээр бүрдсэн парламент нь өмнөх парламентын 1999 онд Үндсэн хуульд оруулж ҮХЦ-ийн 2000 оны 11 сарын 29-ны 02 дугаар тогтоолоор хүчингүй болсон нэмэлт, өөрчлөлтийг агуулгаар нь сэргээж 2000 оны 12 дугаар сарын 14-ны өдөр УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан байдаг. Тус нэмэлт, өөрчлөлт нь иргэдийн оролцоог хангаагүй, төрийн эрх мэдэл хоорондын хяналт-тэнцлийг хангахад сөрөг үр дагавар авчирсан, Үндсэн хуульд тусгайлан заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчимд нийцээгүй арга хэлбэрийг хэрэглэсэн зэргээр “дордуулсан долоон өөрчлөлт” хэмээн нэрлэгдэж шүүмжлэл дагуулж ирсэн.

2022 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр

Бэлтгэсэн:

Судалгааны баг